

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн  
13 дугаар тогтоолын хавсралт

## “Ногоон хөгжлийн бодлого-2030”

**Алсын Хараа:** Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, ногоон, нөхөн сэргээгдэх баялаг, тойргийн эдийн засаг, хүний амьдралын таатай орчин, сайн засаглалтай, өрсөлдөх чадвартай, хөгжлөөрөө тэргүүлэгч аймаг болно.

**Эрхэм зорилго:** Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ХАА, аялал жуулчлал, аж үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд түшиглэсэн эдийн засагтай, ногоон хөгжлийн мэдлэгтэй, оюунлаг, эрүүл иргэнтэй, аюулгүй, амьдрахад таатай орчинтой, хүний хөгжлийг дээдэлсэн, иргэдийн оролцоог хангасан засаглалтай, бус нутагт өрсөлдөх чадвартай, хөгжлөөрөө тэргүүлэгч аймаг болно.

**Стратегийн чиглэл:** Байгаль орчин, эдийн засаг, нийгэм, хүний хөгжил, засаглал

### 1. Байгаль орчны стратеги

**1.1.Стратегийн зорилго:** Байгалийн нөөц, түүх соёлын өв уламжлалыг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хангасан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон аймаг болно.

#### 1.2 Стратегийн зорилт:

1.2.1.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах;

1.2.2.Уур амьсгалын өөрчлөлт, орон нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад Төвийн бүсийн хөгжилд нийцүүлэн хүн амын нутагшил, суурьшлыг төлөвлөн хөгжүүлэх;

1.2.3.Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлсийг хөгжүүлэхэд аймгийн Засаг даргын Тамгын газар, нийтийн ба мэргэжлийн үйлчилгээний байгууллага болон томоохон аж ахуй нэгжийн инновацыг ногоон хөгжлийн хурдасгуур болгох;

1.2.4.Ногоон Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, худалдаа, аялал жуулчлал, үйлчилгээ хөгжүүлэх;

1.2.5.Байгаль орчинд ээлтэй тээвэр, эрчим хүч, дэд бүтцийн хөгжлийг дэмжих;

1.2.6.Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

### **1.3.Зорилтыг хангах үйл ажиллагаа**

**1.3.1.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилтын хүрээнд:**

1.3.1.1.Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эхийг тусгай хамгаалалтад авах;

1.3.1.2.Аймгийн хэмжээнд уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэхийг хязгаарлан, ногоон хөгжлийн жишиг нутаг болгон эко аялал жуулчлал, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх;

1.3.1.3.Аймаг, бүсийн хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлэх төсөл хэрэгжүүлэх;

1.3.1.4.Биологийн олон янз байдлын удмын санг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг тэтгэх замаар хомсдолоос сэргийлэх арга хэмжээ авч ажиллах;

1.3.1.5.Байгалийн ургамал, амьтны генетик нөөцийг зохистой ашиглахад мэргэжлийн байгууллагатай хамтрах, нөөцийн үр өгөөжийг хүртэх нөхцөлийг хангах;

1.3.1.6.Генетикийн аргаар хувиргасан амьд организмын хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх эрсдэлийг үнэлэхэд мэргэжлийн байгууллагатай хамтрах, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, худалдааны хязгаарлалт тогтоох;

1.3.1.7.Ой бүхий нутгийг ашиглан хамгаалах, газар тариалангийн бүс нутагт ойн зурvas байгуулах ажлыг эхлүүлэх, ойгоор бүрхэгдсэн талбайг өргөжүүлж, нүурсхүчлийн хийн шингээлтийг нэмэгдүүлэх;

1.3.1.8.Ой, түүний дагалт баялгийг зохистой ашиглалтад нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг төлөвшүүлэх;

1.3.1.9.Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн хүчин чадал, бүтээмжийг нэмэгдүүлж, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундын усаар хангаж, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх;

1.3.1.10.Төв суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд хашаа хайс барьж тохижуулах, бүсийн дэглэмийг хэрэгжүүлэх

1.3.1.11.Үйлдвэрлэлийн зориулалтаар газрын доорх цэнгэг усны ашиглалтыг хязгаарлан, хаягдал усыг стандартын түвшинд хүртэл цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжих;

1.3.1.12.Хур бороо, цас, үерийн усыг хуримтлуулан хөв цөөрөм байгуулах төсөл(Баянгол сум 2, Баруунбүрэн сум 5, Зүүнбүрэн сум 2, Мандал сум 4, Орхон сум 2, Орхонтуул сум 1, Сант сум 2, Сайхан сум 1, Хушаат сум 4, Цагааннуур сум 3, Шаамар сум 1)<sup>1</sup> хэрэгжүүлэх, газрын доорх усыг нөхөн сэргээх, нөөцийг нэмэгдүүлэх туршилт судалгааг хөхиүлэн дэмжих;

1.3.1.13.Эдийн засгийн хурдацтай өсөлт, уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд хүний үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах хор уршгийг багасгах,

<sup>1</sup> Сэлэнгэ аймгийн хэмжээнд хөв цөөрөм байгуулах боломжит газрын судалгаа



арилгах нөхцөлийг бүрдүүлж хуурайшил, газрын доройтол, цөлжилтийн сөрөг үр дагаврыг бууруулах;

1.3.1.14. Тариаланчдын захиалгаар хүчтэй аадар бороо орох эрсдэлтэй нөхцөлд үүлэнд нөлөөлж эрсдэлийг сааруулах, сумны нөөцийг тариалан бүхий сумуудад байгуулах;

1.3.1.15. Ан амьтны талаар явуулж буй бодлого, зорилгыг хэрэгжүүлэх, агнуурын зүйлүүд өсөж үржих нөхцөлийг хангах, амьдрах орчныг нь хадгалах хамгаалах, орон нутгийн иргэдэд өгөөжтэй ашиглалтыг тогтвортой хөгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг орчин үеийн шаардлагад нийцүүлэх;<sup>2</sup>

1.3.1.16. Уул уурхайн улмаас эвдрэлд орсон, бохирдолд өртсөн, атаршсан газрыг нөхөн сэргээж аж ахуйн зориулалтаар дахин ашиглахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих;

1.3.1.17. Байгалийн баялгийг зохистой ашиглах эрх зүйн зохицуулалт, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах механизмыг боловсронгуй болгох;

1.3.1.18. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу ашиглах.

**1.3.2 Уур амьсгалын өөрчлөлт, орон нутгийн байгалийн нөөц баялаг, сэргэх чадавхад Төвийн бүсийн хөгжилд нийцүүлэн хүн амын нутагшил, суурьшлыг төлөвлөн хөгжүүлэх зорилтын хүрээнд:**

1.3.2.1. Уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн хандлага, байгалийн нөөц даацад нийцүүлж, өөрийгөө тэтгэх чадвартай “Ногоон”, “Ухаалаг” аймаг, сумын төв, тосгоныг хөгжүүлж, орон нутагт тав тухтай ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

1.3.2.2. Аймаг, сумын төв, тосгоны газар ашиглалт, барилгажилтын бүсчлэл, дэд бүтцийн төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах;

1.3.2.3. Аймгийн төв бусад хот суурин газарт ногоон байгууламж байгуулах;

1.3.2.4. Үр ашигтай, хэмнэлттэй технологийг дэмжих, хүн амд амьдрах орчны эрүүл ахуйн мэдлэг, зөв дадлыг олгох замаар хаягдлыг бууруулах зохистой менежментийг төлөвшүүлж, хог хаягдлыг боловсруулж дахин ашиглах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, байгальд булж зайлзуулахад хувийн хэвшилтэй хамтрах;

1.3.2.5. Байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, найдвартай, эрсдэлгүй орон нутгийн тээврийн төрөл, үйлчилгээг хөгжүүлж, иргэд тав тухтай зорчих орчныг бүрдүүлэх;

1.3.2.6. Хот төлөвлөлтийн зохион байгуулалтыг боловсронгуй болгож явган явах, дугуйгаар зорчих орон зайд нэмэгдүүлэх;

**1.3.3 Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлсийг хөгжүүлэхэд аймгийн засаг даргын Тамгын газар, нийтийн ба мэргэжлийн үйлчилгээний**

<sup>2</sup> Ан агнуурын менежментийн төлөвлөгөө

**байгууллага болон томоохон аж ахуй нэгжийн инновацыг ногоон хөгжлийн хурдасгуур болгох зорилтын хүрээнд:**

1.3.3.1.Тогтвортой хөгжлийн боловсролоор дамжуулан эх оронч узэл, байгаль орчноо хамгаалах уламжлалт ёс заншил, байгальд ээлтэй амьдралын хэв маяг, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёлыг төлөвшүүлэх;

1.3.3.2.Байгаль орчны удирдлагын MNS ISO14000 багц стандартыг аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрүүлэхийг хөхиүлэн дэмжиж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээний хэмнэлттэй зөв дадлыг бий болгох;

1.3.3.3.Уул уурхайн болон хөгжлийн томоохон төслийг хэрэгжүүлэхийн өмнө байгаль, түүх, соёлын өвд учруулах эрсдэлийн үнэлгээ хийж, хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

1.3.3.4.Ногоон хөгжлийг дэмжсэн цэвэр технологи, инновацыг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр шийдвэрлэж, ногоон хөгжлийн хурдасгуур болгох;

1.3.3.5.Инновац, биотехнологи, нано технологи дамжуулах, бойжуулах, нутагшуулж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд шинжлэх ухааны байгууллага, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, чанар, онцлогоороо тэргүүлсэн ногоон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.

**1.3.4 Ногоон ХАА аж үйлдвэрлэл, худалдаа, аялал жуулчлал, үйлчилгээ хөгжүүлэх зорилтын хүрээнд:**

1.3.4.1.Эрчим хүчний үйлдвэрлэл, аж үйлдвэрийн технологийг шинэчлэн үрэлгэн хэрэглээ, алдагдлыг бууруулах, эрчим хүчний үр ашигийг нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг нэмэгдүүлж, тус салбарт ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах;

1.3.4.2.Ногоон барилгын үнэлгээний систем, эрчим хүчний аудит зэрэг ногоон шийдэл, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи, стандартыг нутагшуулан нэвтрүүлж, барилгын дулааны алдагдлыг бууруулах;

1.3.4.3.Стандартыг олон улсын жишигт нийцүүлэн тогтоож мөрдүүлэх, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үр дүнг сайжруулах;

1.3.4.4.Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжиж, ногоон технологид суурилсан боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтыг нэмэгдүүлэх;

1.3.4.5.Үр тариа, тэжээл, техникийн ургамлын талбайн хөрсний механик элдэншүүлгийг тэглэсэн, төмс, ногоо, жимсний талбайг цомтгосон технологид шилжүүлэх;

1.3.4.6.Цулгуй уриншийн эргэлтэд эзлэх хувийг бууруулж сэлгээний тоо, сүрлэн хучлагатай талбайг нэмэгдүүлж чийгийн ууршилтыг бууруулах;

1.3.4.7.Төмс хүнсний ногоог хар өнгийн нийлэг хальсаар хучиж, ус чийгийн алдагдал, усалгааны зардал, хог ургамлын ургалтыг бууруулж ургамлын ургалт, болцыг түргэсгэх;

1.3.4.8.Үр тариа, тэжээл, техникийн ургамлын талбайг жилийн 4 улирлын хашаатай болгох;

1.3.4.9.Тариалангийн талбайг хаших хашааны бетон шон, торыг дотоодоо үйлдвэрлэдэг болох;

1.3.4.10.Тариаланчид хамтран талбайдаа хяналт тавих, ургамал хамгааллын бодис, бордоо цацахад дрон ашиглан шатахуун, хөдөлмөр зарцуулалтыг хэмнэж , талбайд явах техникийн тоог цөөлөх;

1.3.4.11.Малчин бүр малынхаа тоо, төрөлд нийцсэн өвс тэжээлийн байнгын нөөцтэй байх журмыг багийн нийт малчид, сумын ИТХ-аараа батлан хэрэгжүүлэх, багийн малчдын дундын өвс тэжээлийн битүү агуулахтай болох;

1.3.4.12.Бүх малыг ээмэгжүүлэх, малын сүргийн толгой /азарга, буур, бух, хуц, ухна/-д чип суулган хөдөлгөөнд хяналт тавих;

1.3.4.13.Сум бүр малчдын зөвлөгөөнөө хийж, малчин бүрд байх малын үүлдэр, угсааг малын төрөл, тооны дээд хязгаарын талаар хэлэлцэн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлах;

1.3.4.14.Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийг дэмжиж, ногоон технологид суурилсан экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж, арьс шир, ноос, ноолуур зэрэг түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх;

1.3.4.15.Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгож, байгальд халгуйгээр хадгалах, савлах технологийг дэмжих.

### **1.3.5.Байгаль орчинд ээлтэй тээвэр, эрчим хүч, дэд бүтцийн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд:**

1.3.5.1.Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын тээврийн үйлчилгээг бий болгоход хувийн хэвшилтэй хамтрах;

1.3.5.2.Эрчим хүчний салбарт нөөцийг үр ашигтай, хаягдалгүй ашиглах технологийг дэмжих;

1.3.5.3.Ил тод, хариуцлагатай олборлох үйлдвэрлэлийг төлөвшүүлж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлэх;

1.3.5.4.Нүүрсний хайгуул, олборлолтод олон улсын стандартыг нутагшуулж мөрдөх, байнгын хяналт шинжилгээ хийх замаар орчны бохирдлоос сэргийлэх;

1.3.5.5.Байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд болон биологийн олон янз байдалд сөрөг нөлөөгүй дэд бүтэц, тээврийн сүлжээг хөгжүүлэх төслийг дэмжих.

### **1.3.6.Ногоон эдийн засгийг дэмжих санхүүжилт, татвар, зээл, урамшууллын оновчтой хөшүүргийг нэвтрүүлж, байгаль хамгаалал, хүний хөгжил, цэвэр технологийг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:**

1.3.6.1.Аймгийн төсвөөс тодорхой хувийг жил бүр ногоон хөгжилд зарцуулж, нэгж бүтээгдэхүүнд ногдох нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах, бүтээмжийг

дээшлүүлэх, байгалийн нөөц ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг өсгөх;

1.3.6.2. Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, хэрэглээний дадлыг төлөвшүүлэх, дэмжих, байгалийн нөөцийн ашиглалтын бүтээмжийг нэмэгдүүлэх эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлэхэд олон улсын хөгжлийн байгууллагаудтай хамтрах;

1.3.6.3. Ойн ус тогтоон барих, нүүрсхүчлийн хий шингээх, голын татмын ус хуримтлуулах, цэвэршүүлэх чадавх зэрэг экосистемийн үйлчилгээг тэтгэн, үр өгөөжийг үнэлж олон нийтэд таниулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд хувийн хэвшилтэй хамтрах;

1.3.6.4. Байгаль орчинд халтай үйлдвэрлэл, үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний импорт, хэрэглээг багасгахад чиглэсэн орон нутгийн захиргааны зохицуулалтыг бий болгох;

1.3.6.5. Аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрт ногоон хөгжлийн зарчмыг тусган бага нүүрстөрөгч бүхий, эрчим хүчний хэмнэлттэй технологийн худалдааг дэмжих;

1.3.6.6. Аймгийн төрийн худалдан авалтыг байгаль орчинд ээлтэй, үр ашигтай, хэмнэлттэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад зарцуулах зохицуулалт хийх;

1.3.6.7. Банк, санхүүгийн байгууллагын байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бий болгож, аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах;

1.3.6.8. Ногоон хөрөнгө оруулалтын эх үүсвэр, санхүүжилтийн боломжуудыг судлах;

1.3.6.9. Орон нутгийн хөгжлийн сангаас ногоон зээл, санхүүжилт олгох боломж хайх;

1.3.6.10. Материалын урсгалын данс, Байгаль-эдийн засаг ба экологийн данс (SEEA EA), Байгаль орчин, нийгмийн засаглал (ESG)-ын индекс зэрэг ногоон хөгжлийн үзүүлэлтийг үндэсний тооцооны системд тусган байгаль орчноос нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг тооцох.

## 2. Эдийн засгийн хөгжлийн стратеги

**2.1. Стратегийн зорилго:** Ногоон хөдөө аж ахуй, аялал жуулчлал, тээвэр, худалдаа, аж үйлдвэрлэл хөгжсөн, бус нутагт өрсөлдөх чадвартай, бие даасан, ногоон тойргийн эдийн засагтай аймаг болно.

### 2.2 Стратегийн зорилт:

2.2.1. Ур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, байгалийн нөөц, эко системд дүйцсэн ногоон, эрчимжсэн ХАА-г хөгжүүлэх;

2.2.2. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй боловсруулах үйлдвэрийг дэмжих;

2.2.3. Байгаль орчинд ээлтэй дамжин өнгөрөх тээвэр худалдаа, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх;

2.2.4.Иргэдийн ая тух, эко орчин, ногоон эрчим хүч, инженерийн дэд бүтэц бүхий хот байгуулалтыг дэмжих;

2.2.5.Аймгийн ойн санг баяжуулан ойн аж ахуйг хөгжүүлэх;

2.2.6 Байгалийн болон дэд бүтцийн даацаад нийцсэн, орон нутгийн иргэдийн хөгжлийг дэмжсэн ногоон эко аялал жуулчлалыг хөгжүүлэх;

2.2.7.Уул уурхайг өнөөгийн түвшинд, нөөцийг үр ашигтай, хаягдалгүй ашиглах технологи бүхий боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

### **2.3. Зорилтыг хангах үйл ажиллагаа**

**2.3.1.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, байгалийн нөөц, эко системд дүйцсэн ногоон, эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлэх зорилтын хүрээнд:**

2.3.1.1 газар тариаланд ойн зурvas байгуулах, газрын доройтлыг бууруулж, сэргээх;

2.3.1.2.Гадаргын усны нөөцөд түшиглэн усалгаатай газар тариаланг нэмэгдүүлж га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх;

2.3.1.3.Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг дотоод, гадаад зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдсан (захиалга, гэрээ, тээвэр, худалдаа, агуулах) логистикийн тогтолцоонд шилжүүлж тогтвортой үйлдвэрлэлийг бий болгох;

2.3.1.4.Төв орон нутгийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн сум бүрд зуны болон 3-4 улирлын хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийг сум бүрд хэрэгжүүлэх;

2.3.1.5.Сумдад 50 мянган толгой сүүний чиглэлийн үхрийн цогцолбор аж ахуй байгуулах;

2.3.1.6.Шаамар, Сүхбаатар сумдад зөгийн бал савлах, экспортод гаргах үйлдвэр байгуулах;

2.3.1.7.Сүхбаатар, Мандал, Орхон сумдад гахай, тахианы аж ахуй байгуулах;

2.3.1.8.Сум бүрд “Шинэ хоршоо” төсөл хэрэгжүүлэх;

2.3.1.9.Аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн логистикийн сүлжээг төлөвлөж хөгжүүлэх;

2.3.1.10.Загасны аж ахуй, байгалийн нөөцөд тулгуурласан жимс, жимсгэнийн аж ахуйг дэмжих;

2.3.1.11.Малчдын захиалга, саналд үндэслэн сум бүрд байх өндөр ашиг шимт монгол нутгийн шилмэл үүлдэр, омгийн малын үржлийн төвүүдийг байгуулах;

2.3.1.12.Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хослон явуулж буй аж ахуйн нэгжүүд, иргэдэд үйлдвэрлэлээ байгальд ээлтэй байдлаар эрчимжүүлэх арга зүйн зөвлөгөө өгөх;

2.3.1.13.Тариаланчид малчидтай хамтран малын өтөг бууц боловсруулж, шим бордоо үйлдвэрлэх санаачилгыг дэмжих;

2.3.1.14. Тариаланчид малчдын захиалгыг үндэслэн тэжээлийн ургамал тариалах, тэжээл үйлдвэрлэх орон нутгийн санаачилгыг дэмжих;

2.3.1.15. Аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн газрын төлөв байдлын үнэлгээ хийж, доройтсон бэлчээр, хадлангийн болон тариалангийн талбайг нөхөн сэргээх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.3.1.16. Нарийн, нарийвтар ноосны үйлдвэрлэл, нийлүүлэлт, боловсруулалтын кластерыг байгуулахад зохион байгуулалтаар дэмжлэг үзүүлэх;

2.3.1.17. Махны үхрийн чанар, ашиг шимийг дээшлүүлэх, махыг нь үйлдвэрийн аргаар боловсруулах, борлуулах маркетингийн кластер байгуулахад зохион байгуулалтаар дэмжих;

2.3.1.18. Үхэр, хонины бордооны талбай байгуулах аж ахуйн нэгж, иргэдийг зохион байгуулалт, арга зүйгээр дэмжих;

2.3.1.19. Тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн сургалтын хөтөлбөр боловсруулж сургалтын материал бэлтгэх;

2.3.1.20. Ногоон санхүүжилтийн сургалтын хөтөлбөр боловсруулж сургалтын материал бэлтгэх;

2.3.1.21. Малчид, тариаланчид, аж ахуйн нэгжүүдэд ногоон хөрөнгө оруулалтын төсөл, ногоон зээлийн хүсэлтээ бэлтгэхэд тусалж, санхүүжүүлэх байгууллагуудтай холбож өгөх;

2.3.1.22. Хөдөө аж ахуй, тэжээлийн салбарт зээлийн үйлчилгээ үзүүлэх нэмэлт эх үүсвэрийн асуудлыг Засгийн газар, Сангийн яам, Монгол банк болон олон улсын хөгжлийн байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх.

### **2.3.2. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:**

2.3.2.1. Аж үйлдвэржилтийн сэргэлтийн хүрээнд Дархан-Сэлэнгийн бүст гангийн үйлдвэрүүд барьж, ашиглалтад оруулах;

2.3.2.2. Төмрийн хүдэр боловсруулах үйлдвэр барих;

2.3.2.3. Сүхбаатар суманд Хөнгөн, хүнсний үйлдвэр барих;

2.3.2.4. Сайхан суманд Барилгын материалын үйлдвэр барих;

2.3.2.5. Сүхбаатар, Мандал, Сайхан, Ерөө сумдад мах бэлтгэлийн үйлдвэр байгуулах;

2.3.2.6. Хушаат суманд Цардуулын үйлдвэр барих;

2.3.2.7. Үйлдвэрүүдийг тоолууржуулах, хэрэглээгээр нь шатлалтай төлбөр авах замаар байгаль орчинд сөрөг нөлөө багатай, үйлдвэрийг дэмжих;

2.3.2.8. Сүхбаатар, Мандал, Баруунбурэн, Баянгол сумдад малын тэжээлийн үйлдвэр барих;

2.3.2.9. Ерөө, Орхон, Цагааннуур сумдад нарийн, нарийвтар ноост хонини цөм сургийн аж ахуй байгуулах;

2.3.2.10.Хүүхдийн хоолны түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлж, орон нутаг болон Дархан, Улаанбаатар хотын зах зээлд нийлүүлэх;

2.3.2.11.Нутгийн онцлог, эрчимжсэн мал аж ахуйд суурилсан анхан шатны болон эцсийн боловсруулах үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлэх;

2.3.2.12.OХУ-аас импортын мод болон үр тариаг боловсруулан БНХАУ-д экспортлох үйлдвэрлэлийг дэмжих;

2.3.2.13.Сум, суурин гарууд дахь мод үржүүлгийн газарт эдийн засгийн шууд үр өгөөжтэй чацааргана, монос, хуш зэрэг модлог жимсгэнийн мод үржүүлгийн аж ахуйг түлхүү дэмжих;

2.3.2.14.Аймгийн хэмжээнд Соёлын бүтээлч аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах;

2.3.2.15.Аймаг, сумын соёлын төвүүдийн үйлчилгээний хүрээг тэлж шинжлэх ухаан, технологийн хөгжлийн төв болгон өргөтгөх;

2.3.2.16.Сум бүрд орон нутгийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимжүүлэх;

2.3.2.17.Зах зээлийн багтаамж ихтэй аймгийн төв, хилийн боомт, чөлөөт бүс, Дархан, Улаанбаатар хотод “Сэлэнгэ брэнд” худалдааны төвийн сүлжээг байгуулах.

**2.3.3.Байгаль орчинд ээлтэй дамжин өнгөрөх тээвэр худалдаа, тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:**

2.3.3.1.Төв коридорыг хос царигтай төмөр зам барих төсөлд дэмжлэг үзүүлэх;

2.3.3.2.Чөлөөт бүс, хилийн боомт, дамжин өнгөрөх авто замын төслүүдийн хүрээнд аймгийн төвд ачаа тээврийн логистикийн төв байгуулахад дэмжлэг үзүүлэх;

2.3.3.3.Боомтын сэргэлтийн хүрээнд Алтанбулаг-Замын Үүд боомтуудыг холбосон 987 км хурдны зам барих ажилд дэмжлэг үзүүлэх;

2.3.3.4.OХУ-аас БНХАУ руу Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх байгалийн хийн хоолой барих бүтээн байгуулалтад орон нутгийн оролцоог хангаж ажиллах;

2.3.3.5.Эдийн засгийн коридор, хуурай боомтын хүрээнд Сүхбаатар өртөөг түшиглэн төмөр замын тээврийн терминалыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулахад дэмжлэг үзүүлэх;

2.3.3.6.Европ болон ОХУ-аас импортолж, Улаанбаатар хот руу шууд нийлүүлж байгаа хүнсний бүтээгдэхүүний логистикийн төвийг Сүхбаатар хотод байгуулах замаар хүнсний болон барааны үнийг бууруулах;

2.3.3.7 БНХАУ-ын тусгай бүс, логистикийн бүстэй хамтран Сүхбаатар, Алтанбулагт төрөлжсөн худалдааны бүс байгуулах, хөндлөнгийн логистик үйлчилгээ үзүүлэх;

2.3.3.8.OХУ-аас БНХАУ-руу экспорт хийх хувийн хэвшлийг дэмжих;

2.3.3.9.АНЗ авто замын коридорын дагуу Зам дагуух үйлчилгээ байгуулахад дэмжлэг үзүүлэх;

2.3.3.10.Дархан-Эрдэнэтийн авто замаас Орхонтуул сум хүртэлх авто замыг улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлэх;

2.3.3.11.Сүхбаатар суманд нисэх онгоцны хөөрч, буух талбай байгуулах;

2.3.3.12.Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх;

2.3.3.13.Орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээг нэмэгдүүлэх;

2.3.3.14.Байгаль орчинд сөрөг нөлөөгүй тээврийн хэрэгслийг дэмжих;

2.3.3.15.Алтанбулаг, Сүхбаатар сумдыг “Боомт хот” болгох;

**2.3.4.Иргэдийн ая тух, эко орчин, ногоон эрчим хүч, инженерийн дэд бүтэц бүхий хот байгуулалтыг дэмжих зорилтын хүрээнд:**

2.3.4.1.Сүхбаатар суманд 50 МВт-ын Дулааны цахилгаан станцыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барих

2.3.4.2.Дахин төлөвлөлт хийж нийтийн болон амины орон сууц барих

2.3.4.3.Ерөө голыг түшиглэн 10 МВт-ын Дулааны станц барих

2.3.4.4.Мандал суманд 50 МВт-ын Дулааны станц барих

2.3.4.5.Сүхбаатар суманд нефтийн бүтээгдэхүүний агуулах барих

2.3.4.6.Хот суурин газарт иргэдийн амрах эко цэцэрлэгт хүрээлэн байгуулах;

2.3.4.7.Айл өрх, аж ахуйн нэгжийн Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжих;

2.3.4.8.Сум, суурин газрын инженерийн дэд бүтцийг байгаль орчинд ээлтэй технологиор шийдвэрлэх;

2.3.4.9.Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын технологийг дэмжих;

2.3.4.10.Байгалийн чулуун хөвөнгөөр хийгдсэн, байгаль орчинд сөрөг нөлөө багатай, шатдаггүй барилгын материалын хэрэглээг дэмжих;

2.3.4.11.Сум, орон нутгийн дулаан хангамжийг байгаль орчинд ээлтэй байдлаар шийдвэрлэхэд хувийн хэвшилтэй хамтрах;

2.3.4.12.Байгаль орчинд сөрөг нөлөө багатай, эдийн засгийн хэмнэлттэй технологиор авто зам, явган хүний зам байгуулахыг дэмжих;

2.3.4.13.Гудамжны гэрэлтүүлэг, камерын системийг нар, салхины эрчих хүчээр хангах;

2.3.4.14.Хот суурин газрын гэр хорооллын ариун цэврийн байгууламж, бичил дэд бүтэц, орчны тохижилт, ногоон байгууламж, тоглоомын талбай байгуулахад хувийн хэвшилтэй хамтрах.

**2.3.5.Аймгийн ойн санг баяжуулан ойн аж ахуйг хөгжүүлэх зорилтын хүрээнд:**

2.3.5.1. Аймгийн ойн сав бүхий газруудыг үе шаттайгаар тусгай хамгаалалтад авах;

2.3.5.2. Аймгийн ойн цэвэрлэгээг хувийн хэвшилтэй хамтран сүм орон нутгийн ажлын байр нэмэгдүүлэх;

2.3.5.3. Ойн сан бүхий сүм бүрд ойн цэвэрлэгээ, унангийг ашиглан Модон хавтан үйлдвэрлэх цех байгуулах;

2.3.5.4. Ойг нөхөн сэргээх, сүм бүрд мод үржүүлгийн газруудыг байгуулж жимс, жимсгэнэ болон ойн нөхөн сэргээлт, тариалангийн ойн зурvasын суулгац үржүүлгийн газруудыг байгуулах үйлдвэрлэлийг “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд эрчимжүүлэх;

2.3.5.5. Аймгийн ДНБ-д ойн аж ахуй эдлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх;

2.3.5.6. Мод үржүүлгийн үйлдвэрлэлийг ой сангүй аймаг, Улаанбаатар хотод үзэсгэлэн худалдаа зохион байгуулах замаар дэмжих;

2.3.5.7. Ойн аж ахуйн эдийн засгийн үнэлгээ, судалгаа хөгжүүлэлт хариуцсан нэгж байгуулах;

2.3.5.8. Ойн түймэр, хортон шавжаас сэргийлэхэд олон улсын байгууллагын дэмжлэг авах ажлыг зохион байгуулах;

2.3.5.9. Ойн баялгийг ашиглах, хамгаалах сан байгуулах;

2.3.5.10. Ойн аж ахуйн төрөлжсөн MCYT, политехникийн коллеж, Коосен байгуулахад дэмжлэг үзүүлэх.

**2.3.6 Байгалийн болон дэд бүтцийн даацад нийцсэн, орон нутгийн иргэдийн хөгжлийг дэмжсэн ногоон эко аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилтын хүрээнд:**

2.3.6.1. Аймгийн аялал жуулчлалын маршрутыг шинэчлэн батлах;

2.3.6.2. Аялал жуулчлалын үйлчилгээг байгаль орчин сөрөг нөлөө багатай байхаар шинэчлэх;

2.3.6.3. “Гэрэлт цогцолбор”, Орхон голыг холбосон дүүжин гүүр барих;

2.3.6.4. Сүм бүрд Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

2.3.6.5. Төмөр зам, улсын чанартай авто замын дагуу гурван улсын Эдийн засгийн коридорын хүрээнд хилийн болон бус нутгийн аялал жуулчлал хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.3.6.6. Рашаан, сувилал, эвент бүхий тусгай аялал жуулчлалыг хөгжүүлэх;

2.3.6.7. “Нэг жуулчин-нэг мод” хөдөлгөөнийг эрчимжүүлэх;

2.3.6.8. Дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх;

2.3.6.9. Аялал жуулчлалын маршрутын дагуу ресторан, хоолны үйлчилгээ, ариун цэвэр, сувинерын худалдааг нэг стандартаар хөгжүүлэх;

2.3.6.10.Аймаг орон нутаг, байгаль, түүх соёлын онцлогийг илэрхийлсэн сувинерын үйлдвэрлэлийг дэмжих;

2.3.6.11.Байгаль орчинд сөрөг нөлөөгүй аялал жуулчлалыг хөгжүүлэх хариуцлагын гэрээг аж ахуй нэгжтэй байгуулах;

2.3.6.12.Жуулчдын аюулгүй байдал, аяллын мэдээ мэдээллээр хангах, виртуал онлайн мэдээллийн систем бий болгож, сурталчилгаанд ашиглах;

**2.3.7.Уул уурхайг өнөөгийн түвшинд, нөөцийг үр ашигтай, хаягдалгүй ашиглах технологи бүхий боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд:**

2.3.7.1.Уул уурхайн эрдэс баялгийн олборлолтыг өнөөгийн түвшинд хадгалах, улмаар бууруулах;

2.3.7.2.Уул уурхайн нөхөн сэргээлтийг олон улсын стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгүүлэхэд хөндлөнгийн баг ажиллуулах;

2.3.7.3.Уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх;

2.3.7.4.Уул уурхайн компаниуд Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) индекс тооцож, тайлагнадаг болох;

2.3.7.5.Уул уурхайн компаниудтай Байгаль орчин, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, жил бүр дүгнэх;

2.3.7.6.Уул уурхайн үйл ажиллагааны худалдан авалтыг орон нутгаас зохион байгуулах;

### **3. Нийгмийн хөгжлийн стратеги**

3.1.Стратегийн зорилго: Боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлтээр тэргүүлсэн, ногоон хөгжлийн мэдлэгтэй, тогтмол орлоготой, нийгмийн эко системийг бүрдүүлсэн, ядууралгүй аймаг болно.

#### **3.2 Стратегийн зорилт:**

3.2.1.Орон нутагт тогтвортой ногоон ажлын байр бий болгох;

3.2.2.Өрхийн судалгаагаар ядуурлыг бууруулах схем боловсруулж, хэрэгжүүлэх;

3.2.3.Сум, орон нутгийн ЕБС-ийн сургалтын чанарыг улсын түвшинд хүргэх;

3.2.4.Иргэдийн эрүүл мэндийн судалгаанд үндэслэн, орон нутгийн онцлогтой эмнэлэг сувилал, сувилахуйн үйлчилгээгээр бүрэн хангах.

#### **3.3.Зорилтыг хангах үйл ажиллагаа**

**3.3.1 Орон нутагт тогтвортой ногоон ажлын байр бий болгох зорилтын хүрээнд:**

3.3.1.1.Сум бүрд орон нутгийн онцлогт тохирсон сумын Үйлдвэрлэл технологийн парк хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулах;

3.3.1.2.Сум, орон нутгийн Засаг захиргааны байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд улс, аймаг, сумын төсвөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдэд эмзэг бүлгийн ядуу өрхийн нэг гишүүнийг эхний ээлжид ажлын байраар хангах;

3.3.1.3.Сум, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ААН, хоршоод нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан авах;

3.3.1.4.Сум орон нутгийн иргэд, малчид, ногоочдын өрхийн үйлдвэрлэлийг түүхий эд болон бүтээгдэхүүнийг нэгдсэн байдлаар зах зээлтэй холбох;

3.3.1.5.Орон нутгийн иргэдийг өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд сургалт зохион байгуулах;

3.3.1.6.Хөдөө аж ахуйн их сургуулийн салбар сургуулийг байгуулах;

3.3.1.7.Орон нутгийн иргэдийг МСҮТ, Политехникийн коллежид сургах замаар хөдөлмөрийн ур чадварыг нэмэгдүүлэх;

**3.3.2.Өрхийн судалгаанд үндэслэн ядуурлыг бууруулах схем боловсруулж, хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:**

3.3.2.1.Сум, орон нутгийн ядуу өрхийн судалгааг жил бүр гаргах;

3.3.2.2.Өрх бүрийн ядуурлыг шалтгааныг тодруулах, ядуурлаас гаргах хилийн төлөвлөгөө гаргах;

3.3.2.3.Эхний ээлжид ядуу өрхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах;

3.3.2.4.Ядуу өрхийг нийгэмшүүлэх, хандлагыг өөрчлөх сэтгэлзүйн туслалцаа үзүүлэх;

3.3.2.5.Ядуу өрхийн чадамжид тохирсон өрхийн үйлдвэрлэлд түүхий эд нийлүүлэх, боловсруулсан бүтээгдэхүүнийг худалдан авах;

**3.3.3.Сум, орон нутгийн Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарыг улсын түвшинд хүргэх зорилтын хүрээнд:**

3.3.3.1.Сум орон нутгийн Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарт үнэлгээ хийх;

3.3.3.2.Ерөнхий боловсролын сургуульд дутагдалтай байгаа багшлах боловсон хүчнийг ангуучилж, тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх;

3.3.3.3.Тухай сумын Ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчтэй сургалтын төлбөрийг хариуцах гэрээ байгуулах замаар багш бэлтгэх;

3.3.3.4.Дотуур байрны хангамжийг нэмэгдүүлэхэд хувийн хэвшилтэй хамтрах;

3.3.3.5.Аймгийн болон улсын олимпиадад бэлтгэхэд орон нутгийн нэмэлт урамшуулалт олгох;

3.3.3.6.Ерөнхий боловсролын сургуулийн дэргэд зохион бүтээх товчоо, байгаль хамгаалах дугуйлан байгуулж, инженерийн сэтгэлгээг хөгжүүлэх;

3.3.3.7. Цэцэрлэг, сургуульд уур амьсгалын өөрчлөлт, байгаль, экологийн мэдлэг олгох;

3.3.3.8. Сургуулийн дэргэд экологийн туршилтын талбайг бий болгох;

3.3.3.9. Ерөнхий боловсролын сургуульд байгаль хамгаалах бүлгэм байгуулах;

**3.3.4. Иргэдийн эрүүл мэндийн судалгаанд үндэслэн, орон нутгийн онцлогтой эмнэлэг сувилал, сувилахуйн үйлчилгээгээр бүрэн хангах зорилтын хүрээнд:**

3.3.4.1. Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгийн үйл ажиллагааг эрчимжүүлж бүр иргэдийг хамруулах;

3.3.4.2. Орон нутгийн онцлогтой халдварт бус өвчлөлийн судалгааг гаргах;

3.3.4.3. Эмнэлгийн орны тоо хэмжээг улсын дундаж хэмжээнд хүргэх;

3.3.4.4. Бүртгэлийн мэдээллийн системийг сайжруулах замаар Амбулаторийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.3.4.5. Цэцэрлэг, сургуулийн хэмжээнд улирлын чанартай халдварт өвчлөлөөс сэргийлэх арга хэмжээ авах;

3.3.4.6. Нарсан ой түшиглэн сэргээн засах цогцолбор сувилал барих;

3.3.4.7. Сум, орон нутгийн рашаан сувилал түшиглэсэн хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулах;

3.3.4.8.Өндөр настны асрах төвийн сүлжээг хувийн хэвшилтэй хамтран сум орон нутагт байгуулах;

3.3.4.9.Өндөр настны асрах төвийн үйл ажиллагааг өнчин хүүхдийн асрах төвтэй хослуулах байгуулахад дэмжлэг үзүүлэх.

#### **4. Хүний хөгжлийн стратеги**

**4.1 Стратегийн зорилго:** Оюунлаг, бүтээлч, эрүүл, өрсөлдөх чадвартай иргэдтэй аймаг болно.

#### **4.2 Стратегийн зорилт:**

4.2.1.Хүний хөгжлийн индексийг нэмэгдүүлэх;

4.2.2.Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны асуудлыг бүрэн шийдвэрлэх;

4.2.3.Аймгийн хэмжээнд хүн ам мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх;

4.2.4.Аймгийн хэмжээнд спорт, үндэсний урлагийг хөгжүүлэх аян зохион байгуулах.

#### **4.3.Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

##### **4.3.1.Хүний хөгжлийн индексийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:**

4.3.1.1.Хүн амын төрөлтийг дэмжсэн, гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх;

4.3.1.2.Сургуулийн өмнөх боловсрол нь хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж цэцэрлэгийн үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулах;

4.3.1.3.Нүүдэлчин ахуй, зан заншил, өв соёлын агуулгыг тусгаж, бүх шатны боловсролын байгууллагын суралцагчдад үндэсний өв соёл, уламжлалт наадгайн төрлийн мэдлэг, чадвар эзэмшүүлэх;

4.3.1.4.Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулах;

4.3.1.5.Бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлж, сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд Цахим хөгжил, өгөгдлийн шинжлэх ухаан, машин сургалт, хиймэл оюун ухаан, зайнаас тандан судлал, газарзүйн мэдээллийн систем зэрэг технологийн талаар оруулах, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлэх;

4.3.1.6.Залуу гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, мэргэжлийн, судалгааны болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

4.3.1.7.Орлогын тэгш бус байдлыг багасган нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэж, нийгмийн зорилтот болон ялгаатай бүлгүүдийн эрх, тэгш оролцоог хангах;

4.3.1.8.Орон сууцны нэг хүнд ногдох талбайн хэмжээг нэмэгдүүлж дэлхийн жишигт хүргэх

4.3.1.9.Орон сууцны чанар, стандартыг ханган, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлэх;

4.3.1.10.Үрийн сан, хөрс хамгаалалт, хөрс боловсруулалт, тариалалт, усалгаа, хураалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, жижиглэн худалдааг хамарсан төмс, хүнсний ногооны мөшгөлтийн мэдээллийн тогтолцоог бий болгон хүнсний аюулгүй байдлыг бүрэн хянах;

#### **4.3.2.Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны асуудлыг бүрэн шийдвэрлэх зорилтын хүрээнд:**

4.3.2.1.Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний хуулийн дагуу орон нутгийн түүхий эдээр сургуул, цэцэрлэгийн хүнсний хангамжийн нэгдсэн тогтолцоог төр, хувын хэвшлийн түншлэлээр бий болгох;

4.3.2.2.Хүүхдийн хөгжлийн судалгаанд үндэслэн хүүхдийн биед дутагдаж байгаа амин дэмээр баялаг хүнсээр аймаг, сум, ААН, эцэг эхийн хамтын ажиллагааны дээр үндэслэн “Сүү”, “Луувангийн шүүс”, “Цэвэр ус,” хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

4.3.2.3.Сум бүрд сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хүнсний хангамжийг хангах цех, сум дундын логистикийн төв байгуулахад хувийн хэвшилтэй хамтрах;

4.3.2.4.Хүүхдийн хоолны хүнсний хангамжийн лабораторийг улсын төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлэх;

4.3.2.5.Хүүхдийн хоолны мэдээллийн системийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулах

4.3.3.Аймгийн хэмжээнд хүн ам мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

4.3.3.1.Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, прогноз, төлөвлөлтөд үндэслэн мэргэжилтэй ажиллах хүчийг бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх;

4.3.3.2.MCYT, Политехникийн коллеж, Коосен сургуулийг бүсчлэн байгуулахад холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтрах;

4.3.3.3.Ажлын байран дээр сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамtran зохион байгуулах;

4.3.3.4.Сум, орон нутгийн номын санг жил бүр орон нутгийн төсвөөр баяжуулалт хийх;

4.3.3.5.Сумын орон нутгийн музей, соёлын төвийг эдийн засгийн эргэлтэд оруулах;

**4.3.4.Аймгийн хэмжээнд спорт, үндэсний урлагийг хөгжүүлэх аян зохион байгуулах зорилтын хүрээнд:**

4.3.4.1.Сум бүрд фитнес клуб байгуулахад хувийн хэвшилтэй хамтрах;

4.3.4.2.Аймаг, бүсийн спортын спартакиадыг жил бүр зохион байгуулах;

4.3.4.3.Үндэсний бөх, сур, наадгайн секц дугуйланг сум бүрд байгуулах;

4.3.4.4.Хөрш орны спортын клубтэй нөхөрсөг тэмцээн зохион байгуулах;

4.3.4.5.Хүүхдийн биеийн хэмжэсийг холбогдох хуулийн дагуу намар болон хавар зохион байгуулахад холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтрах;

4.3.4.6.Аймаг, бүсийн урлагийн наадмыг жил бүр зохион байгуулах;

4.3.4.7.Сэлэнгийн долгио болон бусад үндэсний чуулганы тоглолтыг үндэсний хэмжээнд аялан тоглолт хийхэд дэмжлэг үзүүлэх;

4.3.4.8 залуусын дунд И спортыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

## **5. Сайн засаглалын стратеги**

**5.1 Стратегийн зорилго:**Уур, амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, ногоон тойргийн эдийн засаг, ядууралгүй нийгмийг хөгжүүлсэн, хүн төвтэй, бизнесийн эко системийг бүрдүүлсэн засаглал бүхий аймаг болно.

### **5.2 Стратегийн зорилт:**

5.2.1.Аймгийн бодлого төлөвлөлтийг Төвийн бүсийн бодлого төлөвлөлт уялдуулах;

5.2.2. Ногоон хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн хяналт, шийдвэр гаргалтад цахим хөгжлийн ололт, дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаан ашиглах, хөгжүүлэх;

5.2.3. Аймгийн Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх бүтэц бий болгох;

5.2.4. Байгаль орчинд ээлтэй Аж үйлдвэр, Хөдөө аж ахуй, нийлүүлэлтийн хэлхээний кластерыг байгуулах;

5.2.5. Аймгийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх зорилготой орон нутгийн өмчийн оролцоотой “Сэлэнгэ” хөгжлийн корпорац байгуулах.

### **5.3 Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

**5.3.1. Аймгийн бодлого төлөвлөлтийг Төвийн бүсийн бодлого төлөвлөлт уялдуулах зорилтын хүрээнд:**

5.3.1.1. Төвийн бүсийн аймгуудын ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийг уялдуулах;

5.3.1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн сан бий болгох;

5.3.1.3. Аймгийн бодлого төлөвлөлтэд ногоон хөгжлийн динамик загвартай болох;

5.3.1.4. Бодлого төлөвлөлтийн хүний нөөцийг ажлын байран дээр сургахад мэргэжлийн байгууллагуудтай хамтрах;

5.3.1.5. Уур амьсгалын өөрчлөлтэд дасан зохицох, байгаль орчинд ээлтэй төсөв батлах;

**5.3.2. Ногоон хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн хяналт, шийдвэр гаргалтад цахим хөгжлийн ололт, дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаан ашиглах, хөгжүүлэх зорилтын хүрээнд:**

5.3.2.1. Төвийн бүсийн хөгжлийн бодлого төлөвлөлтэд хиймэл оюун ухаан ашиглах бүтэц бий болгох, шинэ хандлага төлөвшүүлэх, сургалт зохион байгуулах;

5.3.2.2. Хиймэл оюун ухаан ашиглах мэдээллийн систем хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлт, газар зохион байгуулалт, байгаль хамгаалал, хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал, аялал жуулчлал, гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах зэрэг чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх;

**5.3.3. Аймгийн Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх бүтэц бий болгох зорилтын хүрээнд:**

5.3.3.1. Аймгийн Засаг даргын дэргэд ногоон хөгжлийн орон тооны бус зөвлөлийг төр болон хувийн хэвшил, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор байгуулах;

5.3.3.2. Аймгийн засаг даргын Тамгын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэст ногоон хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй болох;

5.3.3.3. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт Ногоон хөгжил хариуцсан нэгжтэй болох;

5.3.3.4. Сум орон нутагт Ногоон хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй болох;

5.3.3.5. Ногоон хөгжлийн бодлогын зарим чиг үүргийг Мэргэжлийн холбоо, Төрийн бус байгууллагад шилжүүлэх

**5.3.4. Байгаль орчинд ээлтэй Аж үйлдвэр, Хөдөө аж ахуй, нийлүүлэлтийн хэлхээний кластерыг байгуулах зорилтын хүрээнд:**

5.3.4.1. Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн төлөвлөлтийг Төв аймгийн хүнсний ногооны үйлдвэрлэлийн төлөвлөлтэй уялдуулах;

5.3.4.2. Зах зээлд чиглэсэн хүнсний үйлдвэрлэлийн нийлүүлэлтийн хэлхээг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодтой хамтран байгуулах;

5.3.4.3. Малын түүхий эд, газар тариалангийн үйлдвэрлэлийг Төвийн бусийн боловсруулах үйлдвэрлэлтэй кластер үүсгэн хамтран ажиллах;

5.3.4.4. Кластерыг дэмжих логистикийн дэд бүтцийг хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулах;

5.3.4.5. Кластерын үйл ажиллагааг дэмжсэн мэдээллийн ERP системийг Олон улсын хөгжлийн байгууллагатай хамтрах;

5.3.4.6. Кластерын үйл ажиллагааг дэмжсэн гадаад худалдааны төрөлжсэн аж ахуй нэгж байгуулах.

**5.3.5. Аймгийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх зорилготой орон нутгийн өмчийн оролцоотой “Сэлэнгэ” хөгжлийн корпорац байгуулах зорилтын хүрээнд:**

5.3.5.1. Аймгийн эдийн засгийн бодлогын хэрэгжилтийг хариуцсан, орон нутгийн өмчийн оролцоотой “Сэлэнгэ” хөгжлийн корпорацыг байгуулах;

5.3.5.2. Аймгийн эдийн засгийн бодлого төлөвлөлт хариуцсан нэгж “Сэлэнгэ” хөгжлийн корпорацын зорилго, зорилт, үйл ажиллагаа бүхий бодлого, жил бүрийн төлөвлөгөөг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлах;

5.3.5.3. “Сэлэнгэ” хөгжлийн корпорацын 34-өөс дээшгүй хувийг иргэдийн Төлөөлөгчдийн хурал, үлдэх хувийг иргэд, хоршоод, аж ахуй нэгж эзэмших;

5.3.5.4. “Сэлэнгэ” хөгжлийн корпорац нь аймгийн эдийн засгийг хөгжүүлэх судалгаа шинжилгээний төвтэй байх;

5.3.5.5. 2030 он гэхэд “Сэлэнгэ” хөгжлийн корпорацын хувьцааг аймгийн иргэдэд хувь эзэмшүүлэх.

## **6. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үе шат**

**Бодлогыг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:**

- I үе шат: 2025-2027 он хүртэл;
- II үе шат: 2028-2030 он хүртэл.

## 7. Бодлогын хэрэгжилтийн үр дүн

7.1.Үүр амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болно.

7.2.Байгалийн нөөцийн зохистой хэрэглээнд суурилсан, хаягдалгүй, ногоон, тойргийн эдийн засагтай болно.

7.3.Бүс нутгийн болон улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зам тээврийн дэд бүтцийн төсөлтэй уялдуулан терминал, логистикийн төв байгуулан бараа бүтээгдэхүүний бөөгнөрлийг бий болгосноор бараа, үйлчилгээний үнэ тогтворжино.

7.4.Газар тариалангийн бүст ойн зурvas байгуулснаар хөрсний эвдрэл, доройтлоос сэргийлнэ.

7.5.Хиймэл нуур, цөөрөм байгуулснаар эко системд эерэг нөлөө үзүүлнэ.

7.6.Атаржсан болон доройтсон газрыг нөхөн сэргээх замаар газрыг доройтлыг бууруулна.

7.7.Гадаргын болон гүний усны нөөцийн зохистой хэрэглээнд түшиглэсэн усалгаатай газар тариалан эрхэлснээр га-аас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.

7.8.Зах зээлийн татах механизмаар хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг зохион байгуулснаар илүү үйлдвэрлэл, хаягдалгүй, ногоон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг бий болгоно.

7.9.Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх замаар малчид ногоочид, тариаланчдын маргааныг шийдвэрлэнэ.

7.10.Байгалийн болон дэд бүтцийн даацад нийцүүлсэн ногоон аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

7.11.Ойн сав газрыг цэвэрлэж ашигласнаар ойн нөхөн сэргэлтийг нэмэгдүүлнэ.

7.12.Мод үржүүлгийн аж ахуйг дэмжсэнээр ойн санг нэмэгдүүлнэ.

7.13.Байгальд ээлтэй, ус бага хэрэглэдэг боловсруулах үйлдвэр хөгжине.

7.14.Хүн амьдрах ая тухай орчин, ногоон байгууламж, ногоон эрчим хүчийг ашиглана.

7.15.Ядууралгүй аймаг болно.

7.16.Хүний хөгжлөөр тэргүүлэгч аймаг болно.

7.17.Аймгийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх Сэлэнгэ хөгжлийн корпорац байгуулна

7.18.Төвийн бүст эдийн засгийн үзүүлэлтээр тэргүүлэгч аймаг болно.

7.19.Цахим хөгжлийн ололт, дэвшилтэт технологи, хиймэл оюун ухаанаар төвийн бүс, аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийг удирдана

7.20. Аймгийн эдийн засгийг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгаль орчинд ээлтэй байдлаар зохион байгуулах Сэлэнгэ хөгжлийн корпорацтай болно.

7.21. Хүн амын цэвэр аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах болон орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалах сайн засаглалын жишиг загвар бий болно.

## **8. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр**

Санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

- Улс, аймаг, орон нутгийн төсөв;
- олон улсын хандив, зээл, тусламж;
- гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- Төр, хувийн хэвшлийн түншлэл;
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
- бусад эх үүсвэр.

## **9. Стратегийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ**

9.1. Бодлогын хэрэгжилтэд 2 жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулна.

9.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлagnana.

9.3. Бодлогын хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

----- о О о -----

**“НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО-2030” БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

ЗОРИЛТ	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	GAME CHANGER ТӨСӨЛ	Суурь түвшин	Зорилтот түвшин		Санхүүгийн эх үүсвэр	Хэрэгжүүлэгч байгууллага
					2025-2027	2028-2030		
<b>1. Байгаль орчны стратеги</b>								
1.3.1 Байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах;	1.3.1.1.Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, цэнгэг усны нөөц, гол, мөрний урсац бүрэлдэх эхийг тусгай хамгаалалтад авах;	Тусгай хамгаалалтад авсан газрын хэмжээ, нийт газар нутагт тусгай хамгаалалттай газрын эзлэх хувь		896,217.9 га	5 хувьар нэмээдүүгсэн байна	10 хувьар нэмээдүүгсэн байна	аймийн төсөө	аймийн ЗДТГ
	1.3.1.2.Аймгийн хэмжээнд уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэхийг хязгаарлан, ногоон хөгжлийн жишиг нутаг болгон эко аялал жуулчлал, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх;	Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй ААН-н тоо, Ашиглалтын болон хайгуулын зориулалттай талбайн хэмжээ		*Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 47047 га бүхий 10 талбай, *хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 67102.5 га бүхий 11 талбай, *түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 9978.2 га бүхий 12 талбай, *бичил уурхайн тусгай зөвшөөрөлтэй 220.1 га бүхий 5 талбай	10 хувьар бууруулах	20 хувьар бууруулах	аймийн төсөө	аймийн ЗДТГ
	1.3.1.3.Аймаг, бусийн хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох аймгийн чадавхыг бэхжүүлэх;	Чадавх бэхжүүлэх сургалтын тоо Сургалтад хамрагдсан хүний тоо, мөнгөн дүн		N/A	10	10	аймийн ЗДТГ	ИТХ
	1.3.1.4.Биологийн олон янз байдлын удмын санг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг тэтгэх замаар хомдолоос сэргийлэх арга хэмжээ авч ажиллах;	Биотехникийн арга хэмжээний тоо,		N/A	Мэдээлэхийн байгууллагатай үхамтарсан байна	тохижуу тоо н байна	аймийн ЗДТГ	аймийн ЗДТГ
	1.3.1.5.Байгалийн ургамал, амьтны генетик нөөцийг зохистой ашиглахад мэргэжлийн байгууллагатай хамтрах, нөөцийн үр өгөөжийг хүртэх нөхцөлийг хангах	Нөөцийн судалгааны тоо, зарцуулсан хөрөнгө, судалсан төрөл зүйлийн тоо		N/A	тохижуу тоо н байна	улс аймийн төсөө	улс аймийн төсөө	улс аймийн төсөө
	1.3.1.5.Мэргэжлийн байгууллагатай хамтран зэрлэг амьтны нөөцийг тогтоож, зохистой ашиглах			N/A	аймийн ЗДТГ	аймийн ЗДТГ	сумын ЗДТГ	сумын ЗДТГ

